



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 7/30

Номгон


Г 7  
Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх  
тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль 15 дугаар зүйлийн 15.3, 15<sup>1</sup>.4, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1, 5.3 дугаар зүйлийн 1, 5.5 дугаар зүйлийн 10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Согтууруулах ундааны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахаар “Чандмань бөмбөгөр” ХХК, “Арвинбулаг тал” ХХК, “Дэлгэрэх таван ихэр” ХХК, “Хонгорын Чандмань эрдэнэ” ХХК-наас хүсэлт ирүүлсний дагуу Тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн Бөмбөгөр сумын С.Сүхбат эзэнтэй “Чандмань бөмбөгөр”, Баянхонгор сумын Ж.Баярмаа эзэнтэй “Жинчин”, Гурванбулаг сумын Т.Сэржпүрэв эзэнтэй “Баянхайрхан” хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг, Баянхонгор сумын С.Сангисүрэн эзэнтэй “Таны зоог”-ийн газрын согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг тус тус 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс 2029 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийг хүртэл 5 жилийн хугацаагаар сунгасугай.

2.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан журам, шийдвэр, цагийн хуваарийг чанд мөрдөж, иргэдэд стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн худалдаалахыг аж ахуйн нэгжийн эздэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль,эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав), аймгийн Цагдаагийн газар (Б.Мөнхбаяр) нарт тус тус даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

642312011